



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 11/102

Ховд

Г Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 39 дүгээр зүйл, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 08 дугаар хуралдааны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 8/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Аймгийн хэмжээнд Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

1.Аймгийн төсвийг бүрдүүлэх ажлын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймагт бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг хуулийн дагуу 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрүүдэд албан татвар төлбөрөө хуулийн хугацаанд төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, аж ахуй нэгж, байгууллагын дутуу төлөлт, татварын өрийг хураан барагдуулах, хариуцлага тооцох хяналт шалгалтыг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал зохион байгуулсугай.

2.Аймгийн хэмжээнд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг зохион байгуулж төсөвт хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/, Цагдаагийн газар /Б.Батзаяа/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Татварын хэлтэс /Х.Батцэцэг/-т тус тус даалгасугай.


4. Албан татвар, төлбөр төлөөгүй авто тээврийн хэрэгслийг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хяналт тавьж замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /Б.Батзаяа/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 18-ны өдрийн
A/102 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Гишүүд:

Т.Жаргалсайхан – Аймгийн Засаг даргын орлогч
Б.Батзаяа – Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн
хурандаа

Х.Батцэцэг – Аймгийн Татварын хэлтсийн дарга

Н.Ирэхзаяа – Автотээврийн төвийн дарга

Н.Балжинням – Замын цагдаагийн тасгийн дарга,
Цагдаагийн хошууч

-Сум, багийн Засаг дарга нар

-оOo-